

## Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх төслүүдийн тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх төслүүдийн тухай” Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтын танилцуулсан илтгэл, холбогдох баримт материалтай танилцаад Монгол Улсын Засгийн газарт ЗӨВЛӨМЖ болгох нь:

1. 2011 оны УИХ-ын 65 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-ын 3 дугаар зүйлийн 4.6-д “Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн судалгаа хийх, бүтээгдэхүүн худалдан авах болон төслийн санхүүжилтэд Засгийн газраас баталгаа гаргах асуудлыг судлах” заалтын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, технологийн сонгон шалгаруулалтын зарчмыг баримталж, төсөл хэрэгжүүлэгчид бүтээгдэхүүн худалдан авах баталгаа гаргах;

2. Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх талаар аж ахуйн нэгжүүдээс гаргасан санал, санаачлага, төслийн хэрэгжилтийн явц, холбогдох баримт бичгийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах;

3. Төслийг энэ онд багтаан эхлүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.